



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/256

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.13 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай олгосугай.

Хүнсний дэлгүүр

1. Хэрлэн сум

Мөнхнэрэн ХХК

Баар, караоке (аялал жуулчлал)

1. Цэнхэрмандал сум

Мөнхмандалт хайрхан ХХК

Баар, караоке

2. Батноров сум

Болор Оюу Эрдэнэ ХХК

Баар, спорт

1. Хэрлэн сум


Аз жаргалтай өглөөний цай ХХК

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн ажлын хэсгийн ахлагч (Б.Өнөрцолмон), Цагдаагийн газрын дарга (дэд хурандаа Э.Жавхлантөгс), Татварын газрын дарга (А.Гантөмөр), Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөр), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ





قصص

[illegible][illegible]

حسرت و پشیمانی

